

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт

Баянтал сумын Засаг даргын Тамгын газар 2022 оны бүтэн жилийн байдлаар

2022.11.01

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1. НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ										
1	1.2. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшинэ.	1.2.1. Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид болон төрийн байгууллагуудын албан хаагчдын Монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, уламжлалт Монгол бичгийг албан хэргийн түвшинд ашиглаж эхэлнэ.	2021 - 2025	4.0 сая	Төрийн байгууллага, албан хаагчдад чиглэсэн сургалт, арга хэмжээний тоо Нийт төрийн албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал, ТЗ-ны албан хаагчдын хамрагдалтын хувь Иргэд, сурагч, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээний тоо Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	Төрийн байгууллага, албан хаагчдад чиглэсэн сургалт, арга хэмжээний тоо-0 Нийт төрийн албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал, ТЗ-ны албан хаагчдын хамрагдалтын хувь-0 Иргэд, сурагч, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээний тоо-2 Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо-685	Төрийн байгууллага, албан хаагчдад чиглэсэн сургалт, арга хэмжээний тоо-5 Нийт төрийн албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал, ТЗ-ны албан хаагчдын хамрагдалтын хувь-50 Иргэд, сурагч, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээний тоо-3 Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо-850		Ерөнхий Боловсролын Сургуулийн 13 багш, ажилтанд “Монгол бичиг”-ийн анхан шатны мэдлэг олгох 25 цагийн сургалтын зохион байгуулсан. Хүмүүн бичиг сониныг нийт 23 багш, ажилтан захиалж, тогтмол уншиж судалж байна. 2022 оны 02 дугаар сарын 26-нд V шатны төслийн хэрэгжилтийн хүрээнд БЕГ-ын монгол хэлний арга зүйч П.Одсүрэнгийн “Монгол хэлний хичээлийн хөтөлбөр боловсруулах” арга зүйн 1 өдрийн танхимын сургалтад бага ангийн 2 багш Говьсүмбэр аймгийн I сургуульд очиж, хамрагдлаа. Багшийн тасралтгүй хөгжлийн хангах үүднээс багш нар маань ээлжлэн ажлын байрны сургалт явуулж байна.#СУРГАЛТ-1. Монгол хэлний багш Нарантуяа Давааням багш, ажилчдад монгол хэлний зөв бичгийн дүрмээр #цуврал сургалт явууллаа. Хүрсэн түвшин: Сонин захиалсан-23 Сургалтад хамрагдсан хүний тоо-2	100

									Гүйцэтгэлийн хувь: 100	
	Хэсгийн дундаж үнэлгээ									100
2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ										
2	2.1. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг тэгш хангана.	2.1.1. Яслид 1-2 насны хүүхдийг, сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны хүүхдийг хамруулан, 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж, сургуульд суралцах бэлтгэлийг хангана.	2021 - 2025	50.0	Хүүхэд харах үйлчилгээний тоо Яслийн бүлгийн тоо Яслийн бүлэгт хамрагдах хүүхдийн тоо 3-5 насны хүүхдийн хамрагдалтын хувь 5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт	Хүүхэд харах үйлчилгээний тоо-1 Яслийн бүлгийн тоо-0 Яслийн бүлэгт хамрагдах хүүхдийн тоо-5 3-5 насны хүүхдийн хамрагдалтын хувь-91 5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь-97.1 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт-91	Хүүхэд харах үйлчилгээний тоо-1 Яслийн бүлгийн тоо-0 Яслийн бүлэгт хамрагдах хүүхдийн тоо-15 3-5 насны хүүхдийн хамрагдалтын хувь-98 5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь-97.7 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт-92.4		2022-2023 оны хичээлийн жилд сумын хамран сургах тойргийн 99 хүүхдээс 86 хүүхэд статистик тоонд орж цэцэрлэгт бүртгэгдсэн. Үүнээс Нүүдлийн бүлгийн 15, танхимаар 71 хүүхэд хамрагдаж байна. Нийт хамрагдалт 86.8% тай байна. 5 настай хүүхдийн хамрагдалт 94.1% хувьтай байна.	86,8
3		2.1.5. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэн, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль,	2021 - 2025	1660.7	Шинээр ашиглалтад орох сургуулийн тоо Шинээр ашиглалтад орох цэцэрлэгийн тоо Засварлах сургууль,	Шинээр ашиглалтад орох сургуулийн тоо-0 Шинээр ашиглалтад орох цэцэрлэгийн тоо-0 Засварлах сургууль, цэцэрлэгийн тоо-	Шинээр ашиглалтад орох анги танхимын тоо-1 Шинээр ашиглалтад орох цэцэрлэгийн тоо-1 Засварлах сургууль, цэцэрлэгийн		Шинээр ашиглалтад орох анги танхимын тоо-1 Засварлах сургууль, цэцэрлэгийн шаардлагатай зураг төсвийг хийлгэнэ. Тоног төхөөрөмжөөр хангасан сургууль, цэцэрлэгийн тоо-2	100
									Тоног төхөөрөмжийн хангалт-80% Туршлага судалсан тоо-2 Ус цэвэршүүлэгчийн тоо-1	

		цэцэрлэгт сурах, хөгжихөд дэмжиж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулна.			цэцэрлэгийн тоо Тоног төхөөрөмжөөр хангасан сургууль, цэцэрлэгийн тоо ЕБС-ийн бүлэг дүүргэлт Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	1 Тоног төхөөрөмжөөр хангасан сургууль, цэцэрлэгийн тоо-5 ЕБС-ийн бүлэг дүүргэлт-31 Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин-98.1 Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо-33	шаардлагатай зураг төсвийг хийлгэнэ. Тоног төхөөрөмжөөр хангасан сургууль, цэцэрлэгийн тоо-7 ЕБС-ийн бүлэг дүүргэлт-31-ээс ихгүй Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин-98.5 Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо-31-аас ихгүй.	<p align="center">Нөлөөллийн тоо-2</p> <p>Говьсүмбэр аймгийн БШУГ-аас танхимаар зохион байгуулсан “Үдийн хоол хөтөлбөр”-ийн сургалтад сургуулийн эмч, тогооч нарын хамт, мөн БШУЯ-наас зохион байгуулсан Ёс зүйн жилийн нээлтийн хэлэлцүүлэгт сургуулийн захирал, нийгмийн ажилтан нарын хамт оролцлоо.</p> <p align="center">Багш, суралцагчдын цэвэр ус уух нөхцөлийг бүрэн 100% шийдвэрлэсэн.</p>	
4		2.1.7. Ерөнхий боловсролын сургуулийн бүх сурагчийг “Үдийн хоол” хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй болно.	2021 - 2025	57.9	“Үдийн хоол” хөтөлбөрийг бага ангид хэрэгжүүлнэ. Төхөөрөмжөөр хангасан сургуулийн тоо Бэлтгэгдсэн мэргэжилтний тоо	Үдийн цай хөтөлбөрийг АНБ-тай гэрээгээр гүйцэтгүүлсэн Төхөөрөмжөөр хангасан сургуулийн тоо- Бэлтгэгдсэн мэргэжилтний тоо-	“Үдийн хоол” хөтөлбөрийг бага ангид хэрэгжүүлнэ Төхөөрөмжөөр хангасан сургуулийн тоо-1 Бэлтгэгдсэн мэргэжилтний тоо-5	<p>Гэрээний хувь-100%</p> <p>Хоолны технологийн картын тоо-50</p> <p>Хяналтын багийн тоо-1</p> <p>Үдийн хоолны хяналтын тоо-77</p> <p>Үйл ажиллагааны дүгнэлтийн тоо-3</p> <p>Манай байгууллага нь төрийн болоод байгууллагын худалдан авах ажиллагааг сумын болоод аймгийн төвийн дэлгүүрүүдтэй тусгай чиглэл чиглэлийн гэрээ байгуулан хийж гүйцэтгэн ажиллаж байна. /худалдан авах гэрээ 2022.01.03-2022.12.31-ний өдрөөр дуусгавар болохоор байгуулагдсан./</p> <p>Хоолны нэр төрлийн технологийн 50 ширхэг картыг бэлтгэн, хэвлэсэн.</p>	100

								<p>Хичээлийн жилийн 1,2 дугаар улиралд цар тахлын үед танхимын сургалт зохион байгуулах журмын дагуу сургуулийн орчинд гадны хүн нэвтрүүлэхгүй байсантай холбоотойгоор үдийн хоолны хяналтыг бага ангийн 5 багш, сургуулийн эмч НА, СМ-ийн бүрэлдэхүүнтэй захирлын тушаалаар томилон, өдөр тутам хяналт хийж, тэмдэглэл хөтлөн, тогоочид зөвлөмж өгч ажиллсан. Хичээлийн 3-р улиралд хяналтын комиссийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, 1-5-р ангийн эцэг эхийн төлөөлөл, сургуулийн эмч, НА, СМ-ийн бүрэлдэхүүнтэй болгон захирлын тушаалаар өөрчилж, өдөр тутам хяналтаа тавин, комиссоос гарсан саналыг тухай бүрд нь тогоочид хэлж, засаж залруулан ажиллаж байна. Мөн 2021-2022 оны хичээлийн жилд үдийн хоолны талаар сэтгэл ханамжийн судалгааг эцэг эхээс цахимаар 1 удаа, сурагчдаас цаасаар 2 удаа, эцэг эхээс цаасаар 1 удаа тус тус зохион байгуулахад цахим санал асуулгад 32 эцэг эх, цаасан санал асуулгад 118 сурагч, 49 эцэг эх тус тус хамрагдсан нь давхардсан тоогоор 199 хүнийг хамарсан цар хүрээтэй ажил болж, санал асуулгын үр дүнг нэгтгэн, тогоочид зөвлөмж хүргүүлж ажилласан. Мөн 1 удаа эцэг эхийн уулзалт зохион байгуулж, үдийн хоолны орц, хэмжээ, бараа бүтээгдэхүүний сав баглаа, боодол, хадгалалт, хяналтын комиссийн бүрэлдэхүүн, тэдний ажил үүргийн талаар мэдээлэл өгч, хоолны амталгаа зохион байгуулж, эцэг эхийн санал сэтгэгдлийг бичүүлж авсан. Энэ үйл ажиллагаанд 20</p>
--	--	--	--	--	--	--	--	--

								<p>эцэг эх хамрагдсан.</p> <p>Үдийн хоолны хяналтыг 1 баг хичээлийн жилийн туршид нийт 150 удаа хийсэн.</p> <p>Үдийн хоолны менюг 7 хоног утам хийж хэвшсэн.</p> <p>Үдийн хоолны заал болон бэлтгэлийн өрөөнд тогооч, үйлчлэгч, жижүүрүүд өөрсдийн нөөцөд тулгуурлан засвар үйлчилгээ хийсэн.</p>	
5	2.1.8. Насан туршийн боловсролын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.	2021 - 2025	11.3	Насан туршийн боловсрол төвийг бүтэцийг шинэчилнэ. Шаардлагатай төсөвийг батлуулна.	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийг түшиглэсэн үйл ажиллагаа явуулсан. Шаардлагатай төсөвийг батлуулна.	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийг түшиглэсэн үйл ажиллагааг 100 хувь явуулсан. Шаардлагатай төсөвийг батлуулсан	<p>Боловсролыг дэмжих арга хэмжээний хүрээнд бичиг үсгийн боловсролгүй иргэдийн тоог бууруулж, сургалтад хамруулах, насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах арга хэмжээг төлөвлөсөн. Тус зорилтын хүрээнд бичиг үсгийн боловсролгүй иргэдийн судалгааг сумын хэмжээнд шинэчлэн 11 иргэний судалгааг гаргасан. Мөн өсвөр залуу үеийнхэнд интерпренершипийн боловсрол олгох хөтөлбөрт хамрагдсан буй сурагчдад</p>	70	



									төсөлд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийг шийдвэрлэх шатахууны зардлыг шийдвэрлэж өгсөн. Хүрсэн түвшин: Насан туршын боловсрол олгох хөлбөрийг боловсруулсан Хэрэгжилт-70	
6	2.2. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг сайжруулж, чадавхыг дээшлүүлнэ.	2.2.1. Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулж, халдварт болон халдварт бус өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	2021 - 2025	14.0	Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулах Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь Вируст гепатитын өвчлөл Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь Сүрьеэ өвчлөлийн түвшин Тэмбүү өвчний түвшин	Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулах- Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь-74.6 Вируст гепатитын өвчлөл-0.0 Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь-33.0 Сүрьеэ өвчлөлийн түвшин-8.9 Тэмбүү өвчний түвшин-16.0	ЭМДТ байгуулсан байна. Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь-76.7 Вируст гепатитын өвчлөл-0.0 Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь-34.5 Сүрьеэ өвчлөлийн түвшин-8.4 ихгүй Тэмбүү өвчний түвшин-16.0 ихгүй	2022 оны эхний 10 сарын байдлаар АГ-332 буюу 47,1% ЧШ-172 буюу 49,7% ХӨХ-171 буюу 75% Умайн-20 буюу 23,3% Элэгний хорт хавдар илэрүүлэх шинжилгээнд Элэгний В-вирус-122 хүнд үзэж 12 хүнд нь В-вирус илэрсэн, С-вирус 127 хүнд үзэж 10-нь С-вирус илэрч хавдраас урьдчилан сэргийлэх арга хэмжээ аван ажилласан Нийт иргэдийн дунд эрт илэрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж сургуулийн 79 хүүхэд, цэцэрлэгийн 42 хүүхдийг урьчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулсан. Хүрсэн түвшин: Эрт илрүүлгийн үзлэг 48,7 хувь хамрагдсан Гүйцэтгэл 100	100	
7		2.2.2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, иргэдийн урьдчилан	2021 - 2025	26.0	Хүн амын дундаж наслалт Мэдээлэл хүртсэн иргэдийн тоо Эрт илрүүлэг үзлэгийн дундаж	Хүн амын дундаж наслалт-73.6 Мэдээлэл хүртсэн иргэдийн тоо-5400 Эрт илрүүлэг үзлэгийн	Хүн амын дундаж наслалт-73.6 Мэдээлэл хүртсэн иргэдийн тоо-500/давхардсан тоогоор/ Эрт илрүүлэг үзлэгийн	Жил бүр Мэдээлэл сургалт сурталчилгааны төлөвлөгөөг гаргаж даргаар батлуулан 100% хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 12 сарын тэмдэглэлт өдрүүдийг календарчилсан хэлбэрээр төлөвлөж хариуцсан мэргэжилтэнгүүдтэй хамтран үйл ажиллагааг жил бүр зохион байгуулснаар 2022-онд 63% тай байна.	100	

		сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, нас баралтын түвшинг бууруулна.			Артерийн даралт ихсэн өвчний эрт илрүүлэг Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралт Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин	дундаж-80.2 Артерийн даралт ихсэн өвчний эрт илрүүлэг-100 Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралт-100 Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин-12.0 Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин-13.2	дундаж-81.0 Артерийн даралт ихсэн өвчний эрт илрүүлэг-50 Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралт-50 Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин-11.8 Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин-12.7	Халдварт бус өвчний сургалт Халдварт өвчний сургалт НҮЭМ-ийн сургалт Бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийн сургалт 6-19 насны хүүхдийн сургалт Мэдээлэл сургалт сурталчилгааны гарын авлагыг 2022-онд 5 төрлөөр 396 ширхэг гарын авлагыг тус тус эхийг бэлтгэн өгч хэвлүүлэн иргэдэд тарааж эрүүл мэндийн боловсрол олгож ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 7 хүүхэд СЭМТ-д хяналтанд байдаг бөгөөд Сургууль-2, цэцэрлэгт – 2 гэрт -3 хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хяналт үзлэг шинжилгээнд тогтмол хамруулж ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 11 эцэг эх, асран халамжлагч нарт эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж 22 ш гарын авлагаар хангасан. Хүрсэн түвшин: Эрт үзлэгийн хувь 100 Гүйцэтгэл- 100	
8		2.2.3. Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нутагшуулна.	2021 - 2025	-	Шинээр нэвтрүүлсэн тусламж үйлчилгээний тоо	Шинээр нэвтрүүлсэн тусламж үйлчилгээний тоо-1	Шинээр нэвтрүүлсэн тусламж үйлчилгээний тоо-1	2022 онд уламжлалт анагаах ухааны чиглэлээр төгссөн эмч мэргэжилтэнтэй. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/611 дүгээр тушаалын дагуу амбулаториор үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн бүртгэлтэй. Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг 2021онд 69 иргэнд, 2022 онд 81 иргэнд үйлчлүүлсэн. Эмчилгээний үр дүнг хувиар илэрхийлвэл биеийн байдал сайжирч, эдгэрсэн 2021 онд 80%-тай, 2022 онд 94 % нь байна Уламжлалын өрөөг тохижуулж байх ёстой тоног төхөөрөмжөөр хангасан Стандарт удирдамжийн чиглэлээр 2019 онд 1 удаа 14 мэргэжилтэн	100

									, 2020 онд 1 удаа сургалт зохион байгуулж 16 эмч мэргэжилтэн, 2021 онд 1 удаа 10 мэргэжилтэн хамрагдсан. Байгууллагын хэмжээнд 7 ш компьютерээр хангаж, дотоод сүлжээнд холбон бүх эмч мэргэжилтнүүдийг интернет ашиглах боломж нөхцлийг бүрдүүлсэн байна.	
9		2.2.7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.	2021 - 2025	15	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь Хүний нөөцийн хангалтын хувь Ур чадвараа сайжруулсан эмчийн тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь-94.1 Хүний нөөцийн хангалтын хувь-87.8 Ур чадвараа сайжруулсан эмчийн тоо-8	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь-100 Хүний нөөцийн хангалтын хувь-88.0 Ур чадвараа сайжруулсан эмчийн тоо-10		Байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дотоодын сургалтанд бүрэн хамруулах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Дорноговь аймаг дахь АШУИСургуульд 1 эмнэлгийн мэргэжилтэнг их эмч бэлтгэх сургалтанд Статистикч бага эмч “Э.Хүрэлбаатар” ыг хамруулахаар сургалтын алба болон байгууллагын удирдлагатай хамтран шийдвэрлүүлж 2022 оны 09 дүгээр сард мэргэжил дээшлүүлж давтан сургалтанд хамруулах бэлтгэл ажил хангагдаж байна. Хүрсэн түвшин: Сургалтад хамруулсан-2 Хэрэгжилт 100 хувь	100
10		2.2.8. Эмнэлгийн хагас бие даасан байдлыг хангах бэлтгэл ажлыг бүрэн хийнэ.	2021 - 2025	-	Сургалтын тоо Сургалтад хамрагдсан ажилтны тоо Төлөөлөн удирдах зөвлөл байгуулах ажлын гүйцэтгэл	Сургалтын тоо- Сургалтад хамрагдсан ажилтны тоо- Төлөөлөн удирдах зөвлөл байгуулах ажлын гүйцэтгэл-	Сургалтын тоо-1 Сургалтад хамрагдсан ажилтны тоо-65 Төлөөлөн удирдах зөвлөл байгуулах ажлын гүйцэтгэл-50	-	Эрүүл мэндийн төвийн ажилтан, ажилчдад дотоодын сургалтаар “чанар гэж юу вэ” “анхан шатны бичиг баримтын хөтлөлт” “яаралтай тусламж” “ эмнэлгийн тоног төхөөрөмжтэй ажиллах” “ковид-19” цар тахалын үед аюулгүй ажиллагаа” хамгаалах хувцас өмсөх тайлах дараалал, эрүүл зохистой хоололт зэрэг сургалтыг зохион байгуулж зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан. Давхардсан тоогоор 64 албан хаагч хамрагдсан байна.	100

									<p>Ковид-19 халдварийн үеийн эмчилгээ оношилгоо , халдвар хамгааллын дэглэмийн сургалтанд ЭМХТ, ЭМЯ, Мэргэжлийн холбоодоос явуулсан Онолайн болон ZUUM-ээр явуулсан сургалтанд 4 удаа оролцож эмнэлгийн эмч, сувилагч, бусад ажилчид мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж ажиллаж байсан нийт 48 хүн хамрагдсан байна.</p> <p>ЭМЯ, ЭМХТ, ЭМГ болон бусад сургуулиудтай хамтран зохион байгуулсан сургалтанд эмч мэрэгжилтнүүдийг бүрэн хамруулж 2020-2022 онд 7 мэргэжилтэн багц цагийн биелэлтийг 100 хангасан. Сургалтанд хамрагдсан бүртгэл судалгаа мэдээний сантай.</p> <p>Төгсөлтийн дараах мэргэжил олгох сургалтанд дархлаажуулалтын сувилагчаар 1 мэргэжилтэн, мэргэжил олгох сургалтанд хамруулсан.</p>	
11	2.4. Шинжлэх ухаан, технологи, инновацыг орон нутагт нэвтрүүлж хэрэгжүүлнэ.	2.4.1. Орон нутагт стандартчилал, хэмжил зүйн нэгж байгуулна.	2021 - 2025	-	Орон нутагт стандартчилал хэмжил зүйн нэгж байгуулна	-	Төсөв хөрөнгийг шийдвэрлүүлнэ.	-	<p>Орон нутагт стандартчилал хэмжил зүйн нэгж байгуулах хүсэлтийг Шадар сайд, Дорноговь аймгийн стандартчилал хэмжил зүйн хэлтэст хүргүүлсний дагуу манай аймагт стандартчилал хэмжил зүйн нэгж байгуулахаар ажлын хэсэг байгуулан хамтран ажиллахаар шийдвэрлэсэн. Хүрсэн түвшин: Холбогдох дээд байгууллагуудад уламжилсан.</p>	50
12		2.4.2. Судалгаа, шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудтай хамтран орон	2021 - 2025	-	Судалгааны ажлын тоо	Судалгааны ажлын тоо-1	Судалгааны ажлын тоо-1	-	<p>Цөлжилтөөс хамгаалах ганд тэсвэртэй модлог ургамал тарималжуулж турших зорилгоор олон хувилбарт туршилт судалгааны ажлуудыг 2019 оноос явуулж байна. 2022 онд хайлаас 5000, улиас 1000, сухай мөчир 5000, төрөл бүрийн үр 10 кг</p>	100

		нутгийн түвшинд судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж, инновацыг нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ.						тус тус тарихаар бэлтгэл ажил хангасан. Газар зүй - геоэкологийн хүрээлэнгээс дээрх судалгааны ажлын дүгнэлтийг 2021 онд гаргаагүй болно. Хүрсэн түвшин: Судалгааны ажлын тоо-1 гүйцэтгэл-100	
13	2.5. Эрүүл баталгаат орчныг бий болгоно.	2.5.2. Эрүүл мэндийн болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээг хийж, орчны бохирдлыг үе шаттайгаар багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	10.0	Орчны шинжилгээ хийлгэх ажлын гүйцэтгэл, хувь Орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тоо Орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт, хувь Ногоон байгууламжийн талбайн хэмжээ, га Шинээр худалдан авсан тоног төхөөрөмжийн тоо	Орчны шинжилгээ хийлгэх ажлын гүйцэтгэл, хувь Орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тоо Орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт, хувь Ногоон байгууламжийн талбайн хэмжээ, га-1 Шинээр худалдан авсан тоног төхөөрөмжийн тоо-	Орчны шинжилгээ хийлгэх ажлын гүйцэтгэл, хувь-100 Орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тоо-19 Орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт, хувь-100 Ногоон байгууламжийн талбайн хэмжээ, га-1.1 Шинээр худалдан авсан тоног төхөөрөмжийн тоо-2	“Албан хаагчид болон иргэдийн нийтээр мод тарих ажлыг 4 удаа зохион байгуулсан бөгөөд тус ажилд нийт 80 албан хаагч, 15 иргэн оролцож 297 ш мод тарьсан. Мөн ХХҮГазар, сумын Засаг даргын гэрээний дагуу “Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн насны 20 иргэдийг хамруулан оролцуулж 160 ш мод тарьж 3.2 сая төгрөгөөр цалинжуулсан. Ахмадын мод тарихад нь зориулж 30 суулгац үнэгүй олгосон. Малчдад хашаа хороогоо хамгаалах, хашсан бэлчээрийн талаар мэдээлэл хийснээр 2 өрх хашаалсан талбайдаа 110 ш мод тарьсан. Мод тарих иргэдэд шаардлагатай суулгацыг татан авах иргэдэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан. -Нийтийн эзэмшлийн гудамж талбайд-357 ш -Иргэн өмчлөлийн газарт тарьсан мод-536 ш -ААНБайгууллага-502ш Нийт 2 га газарт 3,737,000 төгрөгийн 1395 мод бутыгтарьсан байна Хүрсэн түвшин: Талбайн хэмжээ-2 га	100

									Тарьсан мод-1395	
14		2.5.4. Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбож, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.	2021 - 2025	127.5	Баянтал сумын дан байрнуудыг цэвэр, бохир усны шугамд холбох ажлын гүйцэтгэл, хувь Гэр хорооллыг цэвэр усны шугамд холбогдох жишиг зураг боловсруулах ажлын гүйцэтгэл, хувь Шинээр цэвэр усны шугамд холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	Баянтал сумын дан байрнуудыг цэвэр, бохир усны шугамд холбох ажлын гүйцэтгэл, хувь- Гэр хорооллыг цэвэр усны шугамд холбогдох жишиг зураг боловсруулах ажлын гүйцэтгэл, хувь- Шинээр цэвэр усны шугамд холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо- Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь- 48.9	Баянтал сумын дан байрнуудыг цэвэр, бохир усны шугамд холбох ажлын гүйцэтгэл, хувь-100 Гэр хорооллыг цэвэр усны шугамд холбогдох жишиг зураг боловсруулах ажлын гүйцэтгэл, хувь-100 Шинээр цэвэр усны шугамд холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо-100 Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь- 51.6		Баянтал сумын 1-р багийн 2-р хэлхээний сүлжээний өргөтгөлийн зураг төсвийг гүйцэтгэхээр ажиллаж байна. 152, 154-р байрнуудын айл өрхийг цэвэр бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбох ажлын хүрээнд Баянтал сумын 1-р багийн Төмөр замын дан байрнуудын цэвэр бохирын шугамын ажлын тоо хэмжээ, зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байна. Хүрсэн түвшин: Шинээр цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбогдоогүй. Цэвэр усны шугамд холбогдох жишиг зургийн ажлын гүйцэтгэл 70 хувь Шинээр цэвэр усны шугамд холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо -0 Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь 80	70
15	2.6. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого барьж	2.6.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулна.	2021 - 2025	5.0	Зохион байгуулах сургалтын тоо Сургалтад хамрагдсан хүний тоо Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн	Зохион байгуулах сургалтын тоо-1 Сургалтад хамрагдсан хүний тоо-20 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн	Зохион байгуулах сургалтын тоо-2 Сургалтад хамрагдсан хүний тоо-50-аар багагүй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт шалгалтын		Албан хаагчид болон иргэдийн нийтээр мод тарих ажлыг 4 удаа зохион байгуулсан бөгөөд тус ажилд нийт 80 албан хаагч, 15 иргэн оролцож 297 ш мод тарьсан. Мөн ХХҮГазар, сумын Засаг даргын гэрээний дагуу “Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн насны 20 иргэдийг хамруулан оролцуулж 160 ш мод тарьж 3.2 сая	100

	ажиллана.			хяналт шалгалтын тоо	хяналт шалгалтын тоо-2	тоо-14	<p>төгрөгөөр цалинжуулсан. Ахмадын мод тарихад нь зориулж 30 суулгац үнэгүй олгосон. Малчдад хашаа хороогоо хамгаалах, хашсан бэлчээрийн талаар мэдээлэл хийснээр 2 өрх хашаалсан талбайдаа 110 ш мод тарьсан.</p> <p>Мод тарих иргэдэд шаардлагатай суулгацыг татан авах иргэдэд мэдээлэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>-Нийтийн эзэмшлийн гудамж талбайд-357 ш</p> <p>-Иргэн өмчлөлийн газарт тарьсан мод-536 ш</p> <p>-ААНБайгууллага-502ш</p> <p>Нийт 2 га газарт 3,737,000 төгрөгийн 1395 мод бутыгтарьсан байна</p> <p>Хүрсэн түвшин:</p> <p>Талбайн хэмжээ-2 га</p> <p>Тарьсан мод-1395</p>	
16	2.6.2. Ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	ХЭДСА Н 159.0	Ажилгүйдлийн түвшин Ядуурлын түвшин Шинээр бий болсон байнгын ажлын байрны тоо Шинээр бий болсон түр ажлын байрны тоо	Ажилгүйдлийн түвшин-10.5 Ядуурлын түвшин-51.9 Шинээр бий болсон байнгын ажлын байрны тоо-5 Шинээр бий болсон түр ажлын байрны тоо-10	Ажилгүйдлийн түвшин-9.3 Ядуурлын түвшин-50.6 Шинээр бий болсон байнгын ажлын байрны тоо-5-аас доошгүй Шинээр бий болсон түр ажлын байрны тоо-15-аас доошгүй	<p>2022 оны 1-10 р сарын байдлаар ажил хайгчаар 68 иргэн бүртгүүлснээс 51 иргэн сул чөлөөтэй ажлын байранд зуучлагдсан. Үүнээс шинэ ажлын байранд 20 иргэн зуучлагдсан.</p> <p>Хүрсэн түвшин: Шинээр бий болсон байнгын ажлын байрны тоо - 5 Шинээр бий болсон түр ажлын байрны тоо – 15</p>	100

17	2.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ.	2.7.1. Хүн бүр ураг удмаа мэдэж, өрх бүр угийн бичгээ хөтлөх ажлыг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	1.5	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо Угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо Нийт өрхөд эзлэх хувь	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-1313 Угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо-724 Нийт өрхөд эзлэх хувь-14.5	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-2000 Угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо-800 Нийт өрхөд эзлэх хувь-20.0	Сумын Засаг даргын захирамжаар суманд угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулсан. Угийн бичиг хөтлөх аргачлал сургалтыг 2 удаа танхимаар зохион байгуулж нийт 42 өрхийг хамруулсан. Соёлын төвийн ажилтан бүр өрхийн угийн бичгээ хөтлөж эхэлсэн. Хүрсэн түвшин: Арга хэмжээ-1 Хандалт-42 Хэрэгжилт- 50 хувь Хүрсэн түвшин: Хүрсэн түвшин: Хамрагдсан иргэдийн тоо – 10 Угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо – 10	30
18		2.7.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын бүртгэл, хяналтыг сайжруулна.	2021 - 2025	-	Орон нутаг дахь гадаад иргэдийн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал, хувь	Орон нутаг дахь гадаад иргэдийн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал, хувь-100	Орон нутаг дахь гадаад иргэдийн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал, хувь-100	Баянтал сумын гадаад иргэн бүртгэгдээгүй байна. Хүрсэн түвшин: Бүртгэл хийгдсэн хувь-100	100
Хэсгийн дундаж үнэлгээ									88,6
3. ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА									
19	3.1. Нийгмийн дэмжлэг, тусламж зайлшгүй шаардлагатай зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, нийгмийн	3.1.1. Нийгмийн халамж, зорилтот бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээг ил, тод нээлттэй чирэгдэлгүй хүргэнэ.	2021 - 2025	1519.3	Халамжийн үйлчилгээ авсан иргэдийн тоо Үйлчилгээтэй холбоотой гомдол санал гараагүй байна.	Халамжийн үйлчилгээ авсан иргэдийн тоо-3188 -	Халамж хүртэх шаардлагатай иргэний тоогоор Гомдол гараагүй байна.	- Сумын Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн 2022 оны 02 р сарын 21 ны өдрийн 03 дугаар шийдвэрээр ОНОТХҮ – ний Сэргээн засах үйлчилгээнд хамрагдах иргэдийн нэрсийг баталгаажуулсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сэргээн засах үйлчилгээг Говьсүмбэр аймгийн “Гэгээн мандарваа” уламжлалт эмнэлгийн их эмч Б.Цэцэгчимэг, сувилагчийн хамт ирж, тус	100

	харилцаанд идэвхитэй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.								<p>сумын ахмадын хорооны байранд 2022 оны 02 р сарын 28 ны өдрөөс 03 р сарын 04 ны өдрүүдэд зохион байгууллаа.</p> <p>Сэргээн засах үйлчилгээнд ахмад настан 10 хүн хамрагдсанаас байнгын асаргаанд байдаг 3 ахмад настан хамрагдсан. Үйлчилгээнд 1,292.500 төгрөг зарцуулсан</p> <p>-Хүнсний цахим эрхийн бичгийн үйлчилгээнд 5 өрхийн 30 хүн хамрагдаж байна. 1-6 р сарын байдлаар нийт 1,976.000 мян. төгрөг зарцуулсан.</p> <p>Хамрагдсан хүн тоо: 40 Зарцуулсан хөрөнгө: 3,268.000 мян.төгрөг Хэрэгжилт:100%</p>	
20	3.1.2. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	2021 - 2025	ОНТ 24,0 НХС 96,0	Халамжийн үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо Зарцуулсан төсөв-2252.2 сая.	Халамжийн үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо-3188 Зарцуулсан төсөв	Халамж хүртэх шаардлагатай иргэний тоогоор 108.0 сая			<p>1-6 р сарын байдлаар тэтгэвэр, тэтгэмжид 61 хүн хамрагдаж, 52,481.746 төгрөг зарцуулсан.</p> <p>Нийгмийн халамжийн 3 төрлийн тэтгэвэрт нийт 17 иргэн хамрагдаж, нийт 26,624.131 төгрөг олгосон. Үүнд:</p> <p>-Өндөр насны тэтгэврийг 2 хүнд 3,400.258 төгрөг,</p> <p>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийг 13 хүнд 19,450.654 төгрөг,</p> <p>-Тэжээгч нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэврийг 2 иргэнд 3,773.219 төгрөгийг иргэдийн хувийн харилцах данс руу шилжүүлж олгосон.</p> <p>Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжид 42 хүн хамрагдаж, нийт 25,857.615 төгрөг олгосон. Үүнд:</p> <p>-Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа асаргааны тэтгэмжийг 12 иргэнд 5,934.081 төгрөг,</p>	100

								<p>-Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа асаргааны тэтгэмжийг 7 иргэнд 5,170.200 төгрөг,</p> <p>-Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн асарч байгаа асаргааны тэтгэмжийг 2 иргэнд 1,014.000 мян. төгрөг,</p> <p>- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тэтгэмжийг 7 хүүхдэд 12,096.000 мян.төгрөг,</p> <p>- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнд улирал бүр олгох тэтгэмжийг 2 иргэнд 240.000 мян. төгрөг,</p> <p>- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настанд улирал бүр олгох тэтгэмжийг 12 иргэнд 1,403.334 төгрөгийг иргэдийн харилцах дансанд шилжүүлж олгосон.</p> <p>-Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт тусламжийг 19 иргэнд нийт 1,072.000 мян.төгрөг,</p> <p>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн хөнгөлөлт тусламжийг 4 иргэнд нийт 480000 мян.төгрөг тус тус зарцуулсан.</p> <p>Халамжийн үйлчилгээ авсан иргэдийн тоо-84</p> <p>Зарцуулсан хөрөнгө: 54,033.746 төгрөг</p> <p>Хэрэгжилт: 90%</p>		
21	3.2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангана.	3.2.1. 540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн орон сууцны	-	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь-66.6 Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн орон сууцны тоо, айл-20	-	Хүрсэн түвшин: Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь-80 Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн орон сууцны тоо, айл--0	60


					тоо, айл					
22										
23	3.3. Хөдөлмөр эрхлэлт, ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	3.3.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоодын үйл ажиллагааг дэмжинэ.	2021 - 2025	13.5	Зээлийн бодлогоор дэмжинэ. Зохион байгуулсан сургалтын тоо Туршлага судлах арга хэмжээний тоо	-	Зээл олгогдсон байна. Зохион байгуулсан сургалтын тоо-1 Туршлага судлах арга хэмжээний тоо-2		<p>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт “Хүлэмжийн аж ахуй” эрхлэх 1 иргэн төслөө ирүүлсэний дагуу, ажлын хэсгийн гишүүд ирж нөхцөл байдлын судалгаа хийж, ажлын хэсгийн хурлаас дэмжигдэн 6,0 сая төгрөг олгосон.</p> <p>Иргэнийг Аж ахуй эрхлэлтийн 2 өдрийн сургалтанд хамруулсан.</p> <p>2020 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 1 иргэн гэрээний хугацаанаас өмнө эргэн төлөлтийн нийт үлдэгдлээ бүрэн барагдуулсан байна.</p> <p>-Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 5 иргэний төслийг хүлээн авч, ажлын хэсгийн гишүүд төсөл хэрэгжүүлэх газарт очиж нөхцөл байдлын судалгаа хийсэн. Ажлын хэсгийн хурлаас “Хүнсний ногоо тариалах”, “Цагаан идээ хийх”, “Нэхий элдэх” зэрэг /3 иргэн / 3 төсөл дэмжигдэж, тус бүр 5,0 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг олгосон.</p> <p>-ХХҮГ, Сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан Ногоон ажлын байр хөтөлбөрийн хүрээнд “Баянтал-ногоон байгаль” мод тарих ажилд 10, “Тохижилт болон ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа” нийтийг хамарсан ажилд 3 иргэнийг хамруулж, түр ажлын байр бий болгосон.</p>	100

								<p>Байнгын ажлын байрны тоо – 6 /Хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг-4, хоршоо-1, ЗДТГ-1/, Түр ажлын байр – 16 /НХА-13, Хоршоо 3 / Хамрагдсан хүн тоо: 23 Хүрсэн түвшин: Байнгын ажлын байр-6 Түр ажлын байр-16 Хэрэгжилт- 100 хувь</p>	
24	3.4. Биеийн тамир, спортын үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнг нэмэгдүүлнэ.	3.4.1. Нийтийн биеийн тамирыг дэмжиж эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, иргэдийн хамрагдах хувийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	40.0	Арга хэмжээний тоо Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт /насны ангиллаар/ хувь	Арга хэмжээний тоо-17 Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-92.5 Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт /насны ангиллаар/ хувь-10.1	Арга хэмжээний тоо-2 Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт /насны ангиллаар/ хувь-11.7	<p>Биеийн тамирын тэмцээн уралдаанд амжилттай оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор спортын 5 арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Биеийн тамир спортын газартай хамтран заалны гэрээ байгуулж 200 иргэнийг хамруулсан. Олон улсын болон улс бүсийн тэмцээн уралдаанд оролцож буй тамирчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор Шатрын холбоотой хамтран Дэлхийн аваргын шатрын тэмцээнд оролцож буй 1 сурагчид 500,0 төг, Зүүн бүсийн аварга шалгаруулах усан сэлэлтийн тэмцээнд оролцож буй 1 тамирчинд 300,0 төг, Дэлхийн аварга шалгаруулах чөлөөт бүжгийн хар сувд хамтлагт 500,0 дэмжлэгийг тус бүр үзүүлэн ажилласан. Мөн Чойрын богд хайрханы хишиг барилдааныг Үндэсний бөхийн холбоотой хамтран зохион байгуулж 256 бөхийг хамруулсан. Биеийн тамир спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дараах холбоодтой хамтран ажиллалаа. 1.Үндэсний бөхийн холбоотой хамтран</p>	100

								<p>Чойрын богд хайрханы хишиг барилдаан 2.Говийн усчид клубтай хамтран Зүүн бүсийн аварга шалгаруулах усан сэлэлтийн тэмцээн 3.Сансар хайрхан ширээний теннисний клубтай хамтран Сумын засаг даргын нэрэмжит Ширээний теннисний тэмцээн 4.Ахмадын хороотой хамтран ажилласан. Сумын 03-64 насны нийт иргэдийг хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 06 сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хүрсэн түвшин: Арга хэмжээний тоо-5 Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-90 Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт /насны ангиллаар/ хувь -100 Хүрсэн түвшин: Аймгийн биен тамир спортын газраас сумын нийт төрийн байгууллагын албан хаагчдаас бие бялдарын сорил авсан. Нийт 35 албан хаагч хамрагдсан. Гүйцэтгэл-100</p>	
25	3.4.3. Орон нутгийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хувшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан бодлогыг хэрэгжүүлж,	2021 - 2025	61.2	Спортын салбар холбооны тоо Дэмжлэг үзүүлсэн холбооны тоо Дэмжлэгийн хэмжээ, сая.төг	Спортын салбар холбооны тоо-17 Дэмжлэг үзүүлсэн холбооны тоо-17 Дэмжлэгийн хэмжээ, сая.төг-28	Арга хэмжээ -2 Хэрэгжилт 100	<p>Олон улсын болон улс бүсийн тэмцээн уралдаанд оролцож буй тамирчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор Шатрын холбоотой хамтран Дэлхийн аваргын шатрын тэмцээнд оролцож буй 1 сурагчид 500,0 төг, Зүүн бүсийн аварга шалгаруулах усан сэлэлтийн тэмцээнд оролцож буй 1 тамирчинд 300,0 төг, Дэлхийн аварга шалгаруулах чөлөөт бүжгийн хар сувд хамтлагт 500,0 дэмжлэгийг тус бүр үзүүлэн ажилласан. Мөн Чойрын богд хайрханы хишиг барилдааныг Үндэсний бөхийн холбоотой хамтран зохион байгуулж 256 бөхийг хамруулсан. Биеийн тамир спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дараах холбоодтой хамтран ажиллалаа.</p>	100	

		мэргэжлийн спортыг дэмжиж ажиллана.							1.Үндэсний бөхийн холбоотой хамтран Чойрын богд хайрханы хишиг барилдаан 2.Говийн усчид клубтай хамтран Зүүн бүсийн аварга шалгаруулах усан сэлэлтийн тэмцээн 3.Сансар хайрхан ширээний теннисний клубтай хамтран Сумын засаг даргын нэрэмжит Ширээний теннисний тэмцээн 4.Ахмадын хороотой хамтран ажилласан. Хүрсэн түвшин: Спортын салбар холбооны тоо-3 Дэмжлэг үзүүлсэн холбооны тоо – 4 Спортын холбоодод үзүүлсэн дэмжлэгийн хэмжээ -1,300,000 төгрөг	
26	3.5. Аймгийн хэмжээнд газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт,	3.5.1. Хаягжилтын ажлыг үргэлжлүүлэн, мэдээллийн санг хөтлөнө.	2021 - 2025	-	Хаягийн мэдээллийг засварлах сумын тоо Мэдээллийн сангийн баяжилтын гүйцэтгэлийн хувь	Хаягийн мэдээллийг засварлах сумын тоо-0 Мэдээллийн сангийн баяжилтын гүйцэтгэлийн хувь-0	Хаягийн мэдээллийг засварлах сумын тоо-1 Мэдээллийн сангийн баяжилтын гүйцэтгэлийн хувь-100		Хаягийн мэдээллийн систем хэрэглээнд бүрэн нэвтэрч өдөр тутамын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. Хүрсэн түвшин: мэдээлэл-1703 Хэрэгжилт-100	100
27	хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	3.5.2. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	-	Газрын мониторингийн цахим системд программ хангамжийг хөгжүүлнэ.	Газрын мониторингийн хянан баталгааны систем нэвтэрсэн.	Хөгжүүлэлт хийгдсэн байна.		Газар ашиглалт, газрын мониторингийн цахим системийг үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. Уг системээр дамжуулан 2022 онд газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх хугацаа болсониргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэх хуудсыг хүргүүлэн тайлан, дүгнэлтийг цахимаар хүлээн авч баталгаажуулж байна. Хүрсэн түвшин: Цахим системийн хөгжүүлэлт хийгдсэн, өдөр тутамдаа ашиглаж байна.	100

28		3.5.3. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн үйл ажиллагааг сайжруулна.	2021 - 2025	-	Нэгж талбарын тоо Татварын системд илгээсэн нэхэмжлэлийн тоо	Нэгж талбарын тоо-1416 Татварын системд илгээсэн нэхэмжлэлийн тоо-2438	Нэгж талбарын тоо-1000 Татварын системд илгээсэн нэхэмжлэлийн тоо-	Газрын кадастрын мэдээллийн сангийн 1703 нэгж талбар, 93 барилгын орц, гарц хаягийн мэдээллийн сангийн өгөгдөл мэдээллийг сумын ИТХ-аас батлагдсан хаягийн зургийн дагуу хаягийн мэдээллийн санд бүртгэсэн. Мөн шинээр олгосон газруудад хаягийг олгож, ажиллаж байна. Хүрсэн түвшин: Шинээр олгосон газар-6 Хэрэгжилт-100	100	
Хэсгийн дундаж үнэлгээ									96	
4. ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ										
29	4.1. Орон нутагт бизнесийн таатай орчныг бүрдүүлнэ.	4.1.1. Бизнес эрхлэгчдийг чадавхжуулж, инновац, дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ.	2021 - 2025	17.0	Зохион байгуулсан зөвлөгөөний тоо Тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан үйлдвэрлэл эрхлэгчийн тоо	Зохион байгуулсан зөвлөгөөний тоо-0 Тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан үйлдвэрлэл эрхлэгчийн тоо-2	Зохион байгуулсан зөвлөгөөний тоо-1 Тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан үйлдвэрлэл эрхлэгчийн тоо-1	Сум хөгжүүлэх сан нь хоршоо хөгжүүлэх сан болж өөрчлөгдсөн. 2022.03.10-ны өдрийн СИТХ-ын 16-р тогтоолоор Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл, төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын хороо, төсөл сонгон шалгаруулах товыг тогтоолгосон. Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох зарыг цахим, зарлалын самбараар ил тод түгээсэн боловч төсөл ирүүлсэн Хоршоо, байгууллага, ААН байхгүй. Хүрсэн түвшин: Тогтоол баталсан-1 Ил тод байдал-100% Шинээр бий болсон ажил-0 Гүйцэтгэлийн хувь: 70	100	
30	4.2. Орон нутгийн тэргүүлэх салбарын хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.	4.2.2. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, экспортыг дэмжинэ.	2021 - 2025	-	Нөлөөллийн арга хэмжээнд үйлдвэрлэл эрхлэгчдийн хамрагдалтын хувь Үйлдвэрлэсэн арьс, ширний тоо, ширхэг	Нөлөөллийн арга хэмжээнд үйлдвэрлэл эрхлэгчдийн хамрагдалтын хувь-20 Үйлдвэрлэсэн арьс, ширний тоо, ширхэг-	Нөлөөллийн арга хэмжээнд үйлдвэрлэл эрхлэгчдийн хамрагдалтын хувь30 Үйлдвэрлэсэн арьс, ширний тоо, ширхэг-45000	-	2022 оны 05 дугаарын 15 нд Мал аж ахуйн үйлдвэрлэлд ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх сургалт МХГазар, МЭГазар, Чойр Хайрхан ХХК хамтран зохион байгуулсан. Сургалтад орон нутгийн түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, малчин хоршооны 3 гишүүн, 1 ААН төлөөлөл хамрагдлаа. Сургалтаармал аж ахуйн	100

				<p>Угаасан ноосны хэмжээ, тн Ангилсан махны хэмжээ, тн Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн хувь</p>	<p>40000 Угаасан ноосны хэмжээ, тн-250 Ангилсан махны хэмжээ, тн-1.8 Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн хувь-6000 ширхэг</p>	<p>Угаасан ноосны хэмжээ, тн-250 Ангилсан махны хэмжээ, тн-1.8 Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн хувь-1.5</p>	<p>гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нийлүүлэлтийг мөшгөх” цахим системийг хөгжүүлж, оролцогч талуудад сурталчлан таниулах өрхийн үйлдвэрлэж буй түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах, арьс шир, ноос ноолуур бэлтгэн нийлүүлэгчдийн агуулах түр хадгалах цэгийг стандартын шаардлага хангуулах, тээвэрлэлтийн горим, түүхий эдийн чанарыг хамгаалах, зооноз өвчин сэдвээр сургалт зохион байгуулсан. Арьс шир ноос ноолуур бэлтгэх гарын авлага видео контентууд бэлтгэн хүргэж хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх зорилгоор нийт 6 төрлийн гарын авлагаар хангагдсан.</p> <p>ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх талаар мэдээлэл сургалтад 19 малчин хамрагдсан. 1023 :2007 стандарт, мал, амьтны дотор мах, дайвар түүхий эд болон тэдгээрийг ашиглах стандарт танилцуулсан.</p> <p>Үр дүн :</p> <ul style="list-style-type: none"> - Стандартын дагуу түүхий эдийн бэлтгэхэд суралцсан <div data-bbox="1568 1085 1971 1420">  <p>НЭГ СУУРИН БҮТЭЭГДЭХҮҮН АЖИЛ 2022</p> <p>III шатанд тэнцсэн оролцогчид</p> <ul style="list-style-type: none"> "Ширхэнцэг өгөөж" хоршоо "Амгаланзаяа" ХХК "Оорцог элгэн" хоршоо "Цайны их зам" ХХК "Их халбагант" ХХК "Инган тагш" ХХК "Баялаг завш" ХХК "Сүүн зам дайри" ХХК "Чулуут каньон" ББН </div>	<p>- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн</p>
--	--	--	--	---	---	---	--	---

								<p>тогтолцоо бүхий нэг “Загвар хоршоо”-г байгуулах чиглэлээр Оорцог элгэн хоршоог дэмжин үйл ажиллагааг сурталчлан телевизийн бичлэг хийлгэх, мэргэжлийн холбоотой хамтран хоршооны ажилчдыг чадавхижуулах туршлага судлах 2 арга хэмжээг зохион байгуулахад оролцсон.</p> <p>-Налайх дүүргийн Цалуут импэкс махны үйлдвэр, Хэнтий аймгийн Баяновоо Түмэнцогт сумын 6 хоршооны туршлагтай танилцаж “Хоршоодын хөгжлийг хамтдаа бүтээе” улсын хоршоологчдын зөвөлгөөн, туршлага судлах арга хэмжээнд Оорцог-Элгэн хоршооны төлөөлөл хамрагдсан. . “Нутгийн брэнд-Говийн мах махан бүтээгдэхүүн” чиглэлээр хоршоо хөгжүүлэх сангийн зээлд хамрагдаж 85,0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.</p> <p>Үйлдвэрлэсэн арьс, ширний тоо, ширхэг-</p> <p>Угаасан ноосны хэмжээ, тн- Ангилсан махны хэмжээ, тн-2</p>	
31	4.2.3. Хөдөө аж ахуйн болон эрчимжсэн мал аж ахуйн парк байгуулах ажлыг бодлогоор дэмжиж, хөдөө	2021 - 2025	-	Гахайн өрхийн аж ахуйн тоо Шулууны өрхийн аж ахуйн тоо Үйлдвэрлэсэн нийт өндөгний тоо	Гахайн өрхийн аж ахуйн тоо-11 Шулууны өрхийн аж ахуйн тоо-8 Үйлдвэрлэсэн нийт өндөгний тоо-15000	Гахайн өрхийн аж ахуйн тоо-1 Шулууны өрхийн аж ахуйн тоо-1 Үйлдвэрлэсэн нийт өндөгний тоо-15000-аас	-	<p>Сумын хэмжээнд бодлогоор 2 шувууны аж ахуй дэмжсэн. 14-р зөрлөгийн иргэн Баасанхүүгийн “Бөднө шувууны аж ахуй” нь 2021 онд үерт автан үйл ажиллагаа зогсонги байдалд орсон. Иргэн Ж.Гэсэржав нь тахианы аж ахуйгаа эрхэлж байна. 2022 онд Оорцог-Элгэн хоршоо нь мах</p>	100

